



# **Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчны шинэчлэл ба хөрөнгө оруулалтын орчин**

**Жинчанг Лай**

**Санхүүгийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийн Зүүн Ази Номхон Далайн  
бүс нутгийн хариуцсан тэргүүн, Олон улсын санхүүгийн корпораци**

**Улаанбаатар хот, 2019 оны 10 сарын 22**

# Монгол улсын бизнес эрхлэх орчинг сайжруулахад төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн тогтолцоо хамгийн сул хөгжсөн үзүүлэлттэй байна



Эх сурвалж: Бизнес эрхлэхүй судалгаа Дэлхийн банк бүлэг 2019 он

# Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчны шинэчлэл ба хөрөнгө оруулалтын орчин - Жишээ

## Камбоджийн хаант улсад MFone-ийн дараа ч гэсэн төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой эрсдэл ихээр байсаар байна

2015 оны 1 сарын 10

Даниел Дэ Картерет



*Хууль эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдал, энэ талын ойлголт, мэдлэггүй шүүгчид, мөн ийм төрлийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж байсан арга, туршлага байхгүйн улмаас Камбодж улсад төлбөрийн чадваргүй болох, дампуурах үйл ажиллагаа нь маш сэтгэл зовоосон асуудал болоод байна.*

2 жилийн өмнө, 2013 оны 1 сарын 9-ний өдөр харилцаа холбооны оператор компани MFone нь Пном Пенх хотын шүүхэд дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргаж байсан.

Маш их хэмжээний өр төлбөртэй дээр нь нэмээд ширүүн өрсөлдөөнтэй харилцаа холбооны салбарт цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон уг компани нь 1000 гаруй ажилчидыг ажилгүй болгоход хүргэсэн байна. Эдгээр ажилчид нь эргээд гудамжинд гарч эсэргүүцэл илэрхийлж жагссан.

Уг компаниас авлагатай зээлдүүлэгчдийн тоонд Хятадын Хуа Вей (65 сая ам.долларын авлагатай) зэрэг томоохон компаниудаас гадна мөн 20 орчим ам.долларын авлагатай жижиг хэмжээний зээлдүүлэгчид мөн байсан ба эдгээр нь бүгд өр төлбөрөө нэмэмжилж эхэлсэн байна.

Олон жил үргэлжилсэн хуулийн маргааны дараа одоо ч гэсэн Камбодж улсын анхны дампуурлын хэрэг бүрэн шийдэгдээгүй байсаар байна. Гарч байгаа гол бэрхшээлүүдийн нэг нь харилцаа холбооны тоног төхөөрөмжийг худалдах явдал байсан. Тус компаний сүлжээ дамжуулах олон тооны цамхагуудыг улс даяар байршуулсан байгаа ба сүлжээ дамжуулахаа зогссоны дараа уг цамхагуудын үнэ цэнэ маш их буурсан. Мөн үүнээс гадна Камбодж улсын төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль нь маш их цоорхойтой, тодорхой бус байдал ихтэй мөн шүүгчид уг хуулийг ашиглахдаа зохих мэдлэггүй, туршлагагүй байгаа нь харагдсан.

# Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчны шинэчлэл ба хөрөнгө оруулалтын орчин - Жишээ

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн үр дүнтэй байдал нь гадаадын компани тухай улсад хөрөнгө оруулалт хийх эсэх дээр шийдвэр гаргахад маш их чухал байдаг хэмээн гадаадын хөрөнгө оруулагч нарт хууль болон татварын чиглэлээр зөвлөгөө өгч ажилладаг Камбодж улсын VDB Loi компаний ахлах Рутерфорд Хуббарт хэлсэн байдаг.

Тэрээр “Камбодж шиг эрсдэл өндөртэй улсад гадаадын хөрөнгө оруулагч нар хөрөнгө оруулахдаа хэрвээ ямар нэг байдлаар хөрөнгө оруулалт, авлагын үлдэгдлээ нөхөн төлүүлэх хэрэг гарахад дампуурлын хууль эрх зүйн зохицуулалт нь ил тод найдвартай эсэхэд маш их анхаардаг.” гэж хэлжээ. Мөн түүнчлэн “Хэрэв гадаадын хөрөнгө оруулагч нар тухай улсын төлбөрийн чадваргүйдлийн хууль эрх зүйн зохицуулалтанд найдаж болно гэж үзвэл тухайн улс нь хөрөнгө оруулалт хийх таатай зорилтот зах зээл болдог. Харамсалтай нь энэ нь бас эсрэгээрээ үйлчилнэ” гэжээ.

MFone-ийн хэрэг дээр зээлдүүлэгчдийн нэгийг төлөөлж ажиллаж байсан өөрийн нэрийг хэлэхийг хүсээгүй хуульч шүүх хурлууд дээр төлбөрийн чадваргүйдлийн хуулийг тайлбарлаж ойлгох хэрэглэхтэй холбоотой гарч байсан бэрхшээлүүдийн талаар дурссан байна.

Тэрээр “Хэрэв хуультай холбоотой ямар нэг тодорхой бус байдал гарч ирвэл бид бодлого боловсруулагч нараас тодруулга авахаар хүсэлт гаргаж байсан ба эргээд хариу авах гэж маш их уддаг байлаа. Мэдээж энэ хэрэг бол анхны дампуурлын хэрэг ба хэн ч өмнө нь ийм хэрэг дээр ажиллаж байгаагүй, ямар нэг тогтсон аргачлал байхгүй байгааг би ойлгож байна. Иймд бид шүүгч болон ХЗЯмнаас тодруулга авах хүсэлт гаргах хэрэгтэй болдог ба энэ нь маш их цаг хугацаа авдаг бэрхшээлтэй асуудал байсан” гэсэн байна.

MFone-ийн хэрэг дээр хэрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан Ру энэхүү хэргийн талаар “маш хэцүү” байсан гэж хэлсэн байна. Мөн Ру хэлэхдээ “Ижил төстэй хэргүүд мөн бэлэн хувцас, бөс даавуу үйлдвэрлэлийн салбарт гарч байгаа ба үйлдвэрүүд хаагдаж, ажичдаа гудамжинд орхиж байгаа тул Камбоджийн төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулинд итгэх итгэлийг сайжруулах хэрэгтэй байгаа тухай тэмдэглэсэн байна. Камбодж улсын төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг сайжруулснаар бизнес эрхлэгч нар илүү олон сонголттой болох юм. Гэхдээ үүнд хүрэхийн тулд бусад ижил төстэй хэргүүдийг сайн судалж, сургалтуудыг хийх шаардлагатай” хэмээн дурджээ.


# Хөрөнгө оруулагч нарт тодорхой, таамаглаж болохуйц, үр ашигтай байдал хэрэгтэй

- Хувь эзэмших болон зээл олгох бодолтой хөрөнгө оруулагч хөрөнгө оруулахын өмнө ямар зүйлүүдийг анхаардаг вэ?
  - ✓ Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль болон зохицуулалт нь бизнесийн орчинг зохицуулсан суурь хуулиудын салшгүй нэг хэсэг болон хэрэглэгддэг эсэх?
  - ✓ Хувь эзэмших хөрөнгө оруулалт болгон амжилттай байхгүй байж болно. Хэрэв санхүүгийн хүндрэл үүссэн тохиолдолд эвлэрэх, татан буулгах, өөрчлөн байгуулах зэрэг үйл ажиллагаануудыг үр дүнтэй, шударгаар явуулах боломжтой эсэх?
  - ✓ Макро эдийн засгийн тогтвортой байдал байгаа эсэх? Тухайн улсын төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн тогтолцоо муу байснаар санхүүгийн салбарын хямралын үед их хэмжээний шийдвэрлэгдээгүй өр төлбөр бий болоход хүргэнэ. Их хэмжээний шийдвэрлэгдээгүй өр төлбөр нь тогтворгүй байдлыг бий болгож хувь эзэмшил болон зээлийн санхүүжилт хийсэн хөрөнгө оруулагч нарт тодорхой бус байдал үүсгэнэ.
  - ✓ Чанаргүй зээлийн менежмент болон зээл төлбөр төлүүлэх нь зээлийн үйл ажиллагааны салшгүй хэсэг юм. Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн тогтолцоо муу байснаар зээл, санхүүгийн зах зээлийн үр дүнтэй байдлыг бууруулж, бизнес эрхлэгч нарт санхүүжилт авах боломжыг багасгаж, зээл авах зардалыг (зээлийн хүү) өсгөдөг.
  - ✓ Зээл олгосон хөрөнгө оруулагч нарт хэрэв зээлдэгч санхүүгийн хямралд орсон бол зээлээ эргэн хурдан шуурхай эргэн төлүүлэх боломжтой эсэх? Эргэн төлөлтийн хувь хэмжээ ямар байх вэ?
  - ✓ Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн тогтолцоо сайн байвал бизнес эрхлэлт нэмэгддэг

# Хөрөнгө оруулагч нарт тодорхой, таамаглаж болохуйц, үр ашигтай байдал хэрэгтэй

Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн тогтолцоо сайн хөгжсөн улс орнуудад хувийн хэвшилд олгосон зээл, санхүүжилтийн хэмжээ өндөр байдаг

Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн тогтолцооны индекс (0-16)



Хувийн хэвшилд олгосон зээлийн хэмжээ (ДНБ-нд эзлэх хувиар) 2013

Note: Domestic credit to private sector refers to financial resources provided to the private sector by financial corporations, such as through loans, purchases of non-equity securities, and trade credits and other accounts receivable, that establish a claim for repayment. The correlation between the strength of insolvency framework index and domestic credit to private sector as a percentage of GDP is 0.40. The relationship is significant at the 1% level after controlling for income per capita.

Source: Doing Business database; World Bank, World Development Indicators database.

Эх сурвалж: Бизнэс эрхлэхүй судалгаа Дэлхийн банк бүлэг 2015 он

# Хөрөнгө оруулагч нарт тодорхой, таамаглаж болохуйц, үр ашигтай байдал хэрэгтэй

- Чанаргүй зээлийн сайн менежмент болон сайн хөгжсөн төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн тогтолцооны гол шинж чанарууд:
  - ✓ Бизнес амжилтгүй болох магадлалыг хүлээн зөвшөөрч зээлдүүлэгчийн болон нийгмийн эрх ашгийг тэнцвэржүүлэн “дахин оломж олгодог”;
  - ✓ Боломжит олон төрлийн ажиллагаа, сонголтыг санал болгодог, ялангуяа бизнесийг өөрчлөн зохион байгуулах, эдгээр сонголтуудыг ашиглахад хялбар байх
  - ✓ Шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх арга ажиллагаа, боломжууд ихтэй байх
  - ✓ Цаашид үйл ажиллагаа үргэлжлүүлэх, амьдрах боломжтой бизнесийг хадгалж авч үлдэх хандлагатай
  - ✓ Өр төлбөрийн үүрэг гүйцэтгэгч болон зээлдүүлэгч нарын хооронд хялбар байдлаар гэрээ, тохиролцоо байгуулах боломжтой байх
  - ✓ Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх үйл ажиллагааны хэрэг гүйцэтгэгч мэргэжлийн ур чадвар сайтай мэргэжилтнүүдтэй, ажиллагааг явуулдаг мэргэжлийн байгууллагуудтай, мөн өр төлбөр төлүүлэх чиглэлээр ажилладаг мэргэжлийн тусгай компаниудтай байх
  - ✓ Чанаргүй хөрөнгийг арилжах худалдах зах зээлийн тогтолцоо хөгжсөн байх
  - ✓ Чанаргүй зээл шинээр бий болохоос сэргийлсэн үр дүнтэй арга хэмжээг зохицуулагч байгууллагууд авч явуулж чаддаг байх, мөн бий болсон чанаргүй зээлийг хурдан шуурхай шийдвэрлэдэг байх


# Хөрөнгө оруулагч нарт тодорхой, таамаглаж болохуйц, үр ашигтай байдал хэрэгтэй

Figure

Дахин хөрөнгөжүүлэх, дахин зохион байгуулах ажиллагаа нь сайн үр дүнг авчирдаг

2

DB 14 Өр төлбөрийг нөхөн төлүүлсэн хэмжээ



- Эрх хүлээн авах
- Дахин зохион байгуулалт
- Татан буулгалт
- Хөрөнгө зарж борлуулах

Хувийн хэвшилд олгосон зээлийн хэмжээ (ДНБ-нд эзлэх хувиар) 2013

Note: Size of the bubble shows the number of economies. Number inside the bubble shows average recovery rate.


Эх сурвалж: Дэлхийн банк бүлэг 2017 он



# Монгол улсад төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчны шинэчлэл хэрэгтэй

Монгол улсын төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх үзүүлэлтийг бусад орнуудтай харьцуулсан байдал – Авсан оноо болон эзлэсэн байр

Бизнэс эрхлэхүй судалгаа 2019 он – Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх үзүүлэлт – Авсан оноо



Улс орнуудын төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг зээл, өр төлбөрийн эргэн төлөлтийн хувь хэмжээ болон төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчны хөгжлийн түвшний индекс дээр суурилан гаргадаг.

Эх сурвалж: Бизнэс эрхлэхүй судалгаа Дэлхийн банк бүлэг 2019 он

# Монгол улсад төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчны шинэчлэл хэрэгтэй

- Бизнес эрхлэхүй 2019 оны судалгааны 10 гол үзүүлэлтээс Монгол улс “**Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх**” үзүүлэлтээр хамгийн бага оноо авсан байна.
- Дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад **Монгол улсад зээл, өр төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээ хамгийн бага байдаг** ба асуудлыг шийдвэрлэхэд **хамгийн их хугацаа зарцуулдаг**: 16.9 хувь ба 4 жил
- Одоогийн байдлаар төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчны хөгжлийн түвшин нь нийт 16 онооноос 6.5 оноо авсан байна.
  - ✓ Дампуурлын хэрэг үүсгэх: **3 онооноос 2 оноо**
  - ✓ Өр төлбөрийн үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгийг удирдах: **6 онооноос 4 оноо**
  - ✓ Дахин хөрөнгөжүүлэх, дахин зохион байгуулалтанд оруулах ажиллагаа: **3 онооноос 0.5 оноо**
  - ✓ Зээлдүүлэгч нарын оролцоо: **4 онооноос 0 оноо**

# Ойрын хугацаанд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой вэ?

- **Төлбөрийн чадваргүйдлийн хуулийг аль болох хурдан батлаж хэрэгжүүлэх хэрэгтэй байна**
- Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хэрэг гүйцэтгэгч, мэргэжилтнүүдийг бэлтгэж шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх боломжуудыг бий болгох хэрэгтэй байна
- Дахин хөрөнгөжүүлэн, зохион байгуулалтанд оруулах/ зээл, өр төлбөр төлүүлэх/ чанаргүй зээл, хөрөнгийг зарж борлуулах зах зээлийг бий болгох, хөгжүүлэх
- Санхүүгийн салбарын дэд бүтцийн гол элементүүдийг хөгжүүлэх тал дээр зохицуулагч байгууллагууд илүү идэвхтэй ажиллах, зээл, санхүүгийн зах зээл дээрх засаглал болон зээлийн удирдлагын стандартуудыг илүү сайжруулах, одоо байгаа чанаргүй зээлийг хурдан шуурхай шийдвэрлэх (*жишээ нь, сайн дурын гэрээ, тохиролцоог зөвшөөрөх, дахин зохион байгуулалтанд орсон бизнесүүдэд санхүүжилт олгох, г.м*)

# Баярлалаа!

*The views and judgments of this presentation are those of the author. The conclusions and judgments contained herein should not be attributed to and do not necessarily reflect the views of the World Bank Group or IFC, or their management and Board of Directors, or the countries they represent. The author, by means of this document, is not rendering any professional advice or service, and shall not be responsible for any loss sustained by any person who relies on this presentation as a substitute for professional advice or service.*